



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны ээлжит 12 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 12 дугаар хуралдааныг 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулав.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 12 дугаар хуралдаанаар “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай; “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай; Харилцаа холбооны зохицуулах хорооны тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2022 оны 67 тоот тогтоол); “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ” шинэчлэн батлагдсантай холбогдуулан тогтоолыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай (Хорооны 2023 оны 94 тоот тогтоол); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, нэмэлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг тус тус хэлэлцэн хорооны 8 тогтоолыг баталж, хорооны 1 хуралдааны тэмдэглэлээр хугацаатай удирдамж чиглэлийг холбогдох ажлын албанд даалгахаар тогтов.

Тус хорооны 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 3 дугаар хавсралтаар Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг мөрдөж байна. Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн, Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэхтэй болон энэхүү нөхцөл, шаардлагад нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх хүсэлтийг нэр бүхий үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт зэргийг үндэслэл болгон “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын төслийг шинэчлэн боловсруулжээ. ХХЗХ-ны Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газраас “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай танилцуулга, шийдвэрийн төсөл, тогтоолын хавсралт баримт бичгийн төсөл, уулзалт хэлэлцүүлэг, саналыг тусгасан товчоо судалгаа, хуулийн нөлөөллийн шинжилгээг зэрэг баримт бичгийг боловсруулан зохицуулах хорооны 2023 оны ээлжит 12 дугаар хуралдаанд хэлэлцүүлэв. Тус хуралдаанаас Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг үндэслэн 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 105 тоот “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг шинэчлэн батлах тухай” тогтоолыг батлан шийдвэрлэв. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2020 оны 23 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг хүчингүй болгов. Энэхүү тогтоолыг хавсралтын хамт ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан шинээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын албан тоотоор хүргүүлээд байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос Монгол Улсад Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэл (*ХХМТГ-ын Даргын 2020 оны А/45 дугаар тушаал*)-ийг хэрэгжүүлэх, Монгол Улсад 5G Дараа үеийн хөдөлгөөнт холбооны систем нэвтрүүлэх бодлогын хүрээнд зохицуулалтын баримт бичгийг боловсруулах, боловсронгуй болгох; улмаар ЦХХХЯ-наас 2023 онд баталсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-д нийцүүлэх ажлын хүрээнд тус хорооны РДЗХГ-аас “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэх төслийг боловсруулан эрх ашиг нь хөндөгдөж байгаа байгууллага, хуулийн этгээд нартай уулзалт, хэлэлцүүлгийг 2020 оноос зохион байгуулж, баримт бичгийн төслийг боловсруулсан. Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 07 дугаар хуралдаанд Хорооны даргын тушаалаар байгуулсан ажлын хэсгээс /С.Долгорсүрэн, АХ-ын ахлагч/ “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны үндсэн ойлголт судалгааны тайлангийн танилцуулга”; “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэх хэрэгцээ судалгаа”-ны танилцуулга, дэлгэрэнгүй мэдээллийг тусгайлан хэлэлцүүлэн сонгосон болно. Улмаар, 2023 оны ээлжит 08 дугаар хуралдаанд РДЗХГ-аас дээрх ажлын явц болон “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын баримт бичгийн төсөл, албан тоот болон уулзалт, хэлэлцүүлгийн үеэр ирүүлсэн санал, зөвлөмжийг тусгасан эсэх үндэслэл, саналын товчоо зэрэг мэдээлэл, танилцуулгыг хэлэлцээд, хорооны Даргын зөвлөлийн хуралдаанд дахин хэлэлцүүлэх, баримт бичгийн төслийг эцэслэн Хорооны хуралдаанд 2023 оны 08 дугаар сард багтаан хэлэлцүүлж, батлуулах арга хэмжээ авч ажиллахыг РДЗХГ, ажлын албанд үүрэг чиглэл болгосон билээ. Энэхүү удирдамж чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор тус хорооны РДЗХГ, ажлын хэсгээс ХХЗХ-ны 2023 оны ээлжит 12 дугаар хуралдаанд “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэх баримт бичгийн төсөл, танилцуулга, тогтоолын төсөл, Даргын зөвлөлийн хурлын шийдвэр, эрх ашиг нь хөндөгдөж байгаа хуулийн этгээдээс ирүүлсэн санал зөвлөмж, уулзалт хэлэлцүүлэг, ирүүлсэн саналыг тусгасан эсэх товчоо, хуулийн нөлөөллийн шинжилгээг зэрэг баримт бичгийг боловсруулан хэлэлцүүлсэн. Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 12 дугаар хуралдаанаас Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 106 тоот “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэв. Тогтоолыг баталснаар, Дэлхийн радио холбооны дүрэм, Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт болон Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.3, Радио долгионы тухай хуулийн 5¹.1.2 заалтуудыг тус тус үндэслэн Дараа үеийн хөдөлгөөнт холбооны /ДҮХХ/ системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлагыг тодорхойлсон болно. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2018 оны 23 дугаар тогтоол, 2020 оны 24 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болгов. Уг тогтоолыг хавсралтын хамт ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан шинээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын албан тоотоор хүргүүлсэн.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 67 тоот тогтоолоор “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого, зардлын төлөвлөгөө, 2024-2025 оны төсвийн төсөөлөл”-ийг батлан хэрэгжүүлэн

ажиллаж байна. Засгийн газрын шийдвэрээр ХХЗХ-нд БНХАУ-ын зээлийн хөрөнгөөр “Радио, телевизийн хөтөлбөрт байнгын хяналт, мониторинг хийх хяналтын нэгдсэн систем байгуулах” төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлээд байгаа бөгөөд төсөл хэрэгжүүлэх бэлтгэл арга хэмжээг авах, Зээлийн гэрээг байгуулахад төсөл хэрэгжүүлэгч-Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2023 онд хөрөнгө оруулалтын холбогдох нөөц хөрөнгө бүрдүүлэх, нэр бүхий хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрт өөрчлөлт оруулах, нэмэлт оруулах зорилгоор 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, зардалд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарсан болно. Тус хорооны ЗУХАГ, Санхүүгийн хэлтэс, Хуулийн хэлтэс, холбогдох газрууд хамтран зохицуулах хорооны 2023 оны ээлжит 12 дугаар хуралдаанд Харилцаа холбооны зохицуулах хорооны тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах (Хорооны 2022 оны 67 тоот тогтоол) тухай танилцуулга, тогтоолын төсөл, зээлийн төсөл болон гэрээний нөхцөл шаардлагууд, зээлийн тооцоо судалгаа, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах үндэслэл тооцоолол, зээлийн төслийн танилцуулга зэргийг боловсруулан хэлэлцүүлэв. Хэлэлцсэн энэхүү асуудлаар, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.16 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 268 тоот тогтоолын хавсралтаар батлагдаж, 2020 оны 67 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 107 тоот “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг баталж, ХХЗХ-ны 2022 оны 67 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого, зардлын төлөвлөгөө”-нд холбогдох нэмэлт өөрчлөлтийг тус тус оруулан шийдвэрлэв.

ХХЗХ-ны 2023 оны 94 тоот тогтоолоор “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г шинэчлэн баталж, уг тогтоолыг ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд хянуулж, 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдөр бүртгүүлэн мөрдөж эхлээд байна. Тус хорооны хуралдаанаар “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г шинэчлэн баталсантай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай танилцуулга, хуралдааны тэмдэглэлийн төсөл, тогтоолыг мөрдөж эхлэхэд Тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний шинэчилсэн төлбөрийн хэмжээг хэрхэн системд бүртгэх, тооцоолох, нэхэмжлэх тухай саналын талаар хэлэлцэв. Уг асуудлаар 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 05 тоот хуралдааны “Хорооны тогтоолыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Тэмдэглэлийг баталсан ба энэхүү хуралдааны тэмдэглэлээр, Хорооны 2023 оны 94 тоот тогтоолыг ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн тус хорооны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу байгууллагын санхүү бүртгэлийн нэгдсэн системд холбогдох өөрчлөлтийг оруулах; эдгээр өөрчлөлтийг санхүү бүртгэлийн нэгдсэн системд оруулах хугацаанд радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийг тус тус тооцоолж, хэрэглэгчдээс нэхэмжлэн тайлагнах; энэхүү хуралдааны тэмдэглэлийг хэрэгжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хэрэгжилтийн тайланг 2024 оны 01 дүгээр улиралд багтаан Хорооны хуралдаанд хэлэлцүүлэхийг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/, Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газар /З.Амгалан/-т үүрэг болгохоор тус тус тогтов.

Хорооны 2023 оны ээлжит 12 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, нэмэлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ,

дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлт) холбогдох газар хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 5 тогтоол, хавсралтын төслийг тус тус авч хэлэлцээд, тус хуралдаанаас 5 тогтоолыг хавсралтын хамт баталсан. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 108 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 109 тоот тогтоолын хавсралтаар 5 хуулийн этгээдийн 7 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 110 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөлд нэмэлт оруулсан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт болон Түмтшанд ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 111 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 112 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдэд 1 харилцаа холбооны сүлжээний дугаарыг олгож тус тус шийдвэрлэсэн.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2023-09-22